



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 07 өдөр

Дугаар A/491

Арвайхээр

Эрх шилжүүлэх тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Төсөвт өөрчлөлт оруулах тухай” 26 дугаар тогтоолын 2.8-т батлагдсан Арвайхээр сумын Нарны дөш, Түшиг дөлгөөн, Уян сэтгэл Эрүүл мэндийн төвүүдийн автомашин 36.000.000 (гучин зургаан сая) төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг Арвайхээр сумын Засаг даргад шилжүүлсүгэй.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг Арвайхээр сумын Засаг дарга (О.Пүрэвдорж)-д даалгасугай.

3. Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100852